



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1999 оны 9 дугаар
сарын 30 өдөр

Дугаар А-209

Улаанбаатар
хот

Зарим байгууллагын талаар
авах арга хэмжээний тухай

Нэг. Монгол Улсын Их Хурлын "Аймаг, нийслэлийн өмчлөлд эд хөрөнгө шилжүүлэх тухай" 1999 оны 29 дүгээр тогтоолын дагуу нийслэлийн өмчлөлд "Соёлын төв өргөө" цогцолбор шилжиж ирсэнтэй холбогдуулан уг цогцолборыг эзэмшиж, үйл ажиллагаа явуулах төсөвт үйлдвэрийн газрын Нийслэлийн Соёлын газрын харъяалалд "Нийслэлийн Соёлын төв өргөө" нэртэйгээр энэ оны 10 дугаар сарын 1-нээс байгуулсугай.


Хоёр. "Нийслэлийн Соёлын төв өргөө" төсөвт үйлдвэрийн газрын захирлаар Бадам овогтой Байгальмааг томилсугай.

Гурав. "Нийслэлийн Соёлын төв өргөө" төсөвт үйлдвэрийн газрын бүтэц зохион байгуулалт, дүрмийг 10 дугаар сарын 10-ны дотор боловсруулж батлуулахыг Өмчийн газар /Б.Буянмөнх/, Соёлын газар /Л.Нямсамбуу/, "Нийслэлийн Соёлын төв өргөө" төсөвт үйлдвэрийн газар /Б.Байгальмаа/-т тус тус үүрэг болгосугай.

Дөрөв. "Нийслэлийн Соёлын төв өргөө" байгуулагдсантай холбогдуулан Нийслэлийн Соёлын төвийг татан буулгаж, эзэмшиж байсан барилгыг нь нийслэлийн Ахмадын хороонд Ахмадын соёлын төвийн зориулалтаар эзэмшүүлсүгэй.

Тав. Хотын Соёлын төвийн балансанд байсан барилга, эд хөрөнгийг нийслэлийн Өмчийн газрын балансанд шилжүүлж, нийслэлийн Ахмадын хороонд, "Соёлын төв өргөө" цогцолборын барилга байгууламж, эд хөрөнгийг "Нийслэлийн Соёлын төв өргөө" төсөвт үйлдвэрийн газарт тус тус хүлээлгэн өгч, "Нийслэлийн Соёлын төв өргөө"-тэй түрээсийн, нийслэлийн Ахмадын хороотой өмч эзэмшлийн гэрээ байгуулж ажиллахыг Өмчийн газар /Б.Буянмөнх/-т зөвшөөрсүгэй.

Зургаа. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Улаанбаатар хотын АХ-ын гүйцэтгэх захиргааны 1991 оны 355 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ


М.ЭНХБОЛД